

БАТЛАВ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА *З.Баяндугар* З.БАЯНДУГАР
2025 оны 02 сарын 17-ний өдөр

4611462
ГСТ7460 3223010003

**2025 ОНЫ МОДОН МОГОЙ ЖИЛИЙГ УГТСАН "АМАР БАЙНА УУ"
НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ**

НЭГ: ЗОРИЛГО

1.1. Тус аймгийн сумдын иргэдэд улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээллээр ханган, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн талаар мэдээлэл олгон, тоон гарын үсэг олголтын ажлыг эрчимжүүлэх, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аймаг хотоос шилжин ирж буй иргэдийн тоог нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

2.1. Сүмбэр сум, Шивээговь сум, Баянтал сумдын иргэд хамрагдана.

Баянтал суманд: 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 10:00-14:00 цагийн хооронд /Баянтал сумын ЗДТГ-ын иргэний танхимд /

Шивээговь суманд: 2025 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 10:00-14:00 цагийн хооронд /Шивээговь сумын соёлын төвд/

Сүмбэр суманд: 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 08:30-17:30 цагийн хооронд /Хэлтсийн иргэдэд үйлчлэх танхимд/ тус тус зохион байгуулна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨР

№	Хичээлийн нэр, агуулга	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс
1	Тоног төхөөрөмж холболт	Сүмбэр суманд 08:30-08:40, Шивээговь, Баянтал сумдад 10:00-10:10	Мэдээлэл технологийн ажилтан Б.Дөлгөөнмөрөн
2	Өдөрлөгийн нээлт	Сүмбэр суманд 08:40-08:50, Шивээговь, Баянтал сумдад 10:10-10:20	Хэлтсийн дарга З.Баяндугар
3	Улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээнүүдийн товч танилцуулга	Сүмбэр суманд 08:50-09:00, Шивээговь, Баянтал сумдад 10:20-10:30	Хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Э.Ууганбат, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ч.Бүрэнжаргал
4	Тоон гарын үсэг, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар мэдээлэл, танилцуулга, Зөрчлийн тухай хууль	Сүмбэр суманд 09:00-09:10, Шивээговь, Баянтал сумдад 10:30-10:40	Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ч.Бүрэнжаргал, Хяналтын улсын байцаагч Т.Цэвэлмаа
5	Иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл	Сүмбэр суманд 09:10-17:30, Шивээговь, Баянтал сумдад 10:40-14:00	Тасгийн дарга, Хяналтын улсын байцаагч, Улсын бүртгэгч нар

6	Үйлчлүүлсэн иргэдийн дундах буузны азтан шалгаруулах сугалаа	Сүмбэр суманд 17:30-17:40, Шивээговь, Баянтал сумдад 14:00-14:10	Мэдээлэл технологийн ажилтан Б.Дөлгөөнмөрөн
---	--	--	---

ДӨРӨВ. БУСАД:

Өдөрлөгийг иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Ч.Бүрэнжаргал чиглүүлэн зохион байгуулж өдөрлөгийн тайланг 2025.02.21-ний өдөр хэлтсийн даргад танилцуулна.

**2025 ОНЫ МОДОН МОГОЙ ЖИЛИЙГ УГТСАН “АМАР БАЙНА УУ”
НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.02.21

Чойр хот

Тус хэлтэс нь модон могой жилийн сар шинийн баярыг угтан “Амар байна уу” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 2025.02.17-2025.02.19-ний өдрүүдийн хооронд Баянтал, Шивээговь, Сүмбэр сумдын 169 иргэн, хуулийн этгээдэд Улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг хүргэн түргэн шуурхай үйлчилж амжилттай зохион байгуулж ажиллалаа. Бүртгэл тус бүрээр харуулбал Үүнд:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр **нийт-137**

- Төрөлт-5
- Үрчлэлт-1
- Овог, эцэг эхийн нэр, нэр өөрчлөлт-1
- Эцэг тогтоолт-1
- Гэрлэлт цуцлалт-1
- Бусад аймаг хотоос шилжин ирсэн-11 / 5 том хүн, 7 хүүхэд /, үүнээс Улаанбаатар хотоос-7 / 3 том хүн, 4 хүүхэд /
- Аймаг доторх шилжилт хөдөлгөөний бүртгэл-10 /4 том хүн, 6 хүүхэд/
- Төрсний гэрчилгээ дахин олголт-3
- ИШБ-д хамрагдсан-18 / Шинэ, хугацаа сунгалт/
- Гадаад паспортын бүртгэл-15
- Лавлагаа авсан-36
- Тоон гарын үсэг-35

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр **нийт-32**

- Газрын анхны бүртгэл-1
- Гэрчилгээ олголт-7
- Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөлт-1
- Барьцаа-8
- Барьцаа өөрчлөлт-4
- Барьцаа чөлөөлөх-7
- Анхны бүртгэл-2
- Худалдах худалдан авах-1
- Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт-1

Мөн сум тус бүрээс үйлчилгээ авсан иргэдийн дунд сугалаа бэлтгэн хэлтсийн албан хаагчид өөрсдийн гараар хийсэн сар шинийн буузны азтаныг шалгаруулан, гардуулан өгсөн.

Баянтал сумаас- Лүн багийн иргэн Б.Бямбасүрэн

Шивээговь сумаас- 1-р багийн иргэн Ш.Сайн-Амар

Сүмбэр сумаас-1-р багийн иргэн Ц.Эрдэнэчимэг нар азтанаар шалгарсан.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ



Ч.БҮРЭНЖАРГАЛ